



Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээр үйлчлүүлж буй иргэдээс авсан 2023 оны 7-р сарын сэтгэл ханамжийн судалгааны нэгтгэл

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО: Энэхүү судалгаа нь Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээг сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийн дээшлүүлэхэд оршино.

СЭТГЭЛ ХАНАМЖ: Сэтгэл ханамж гэдэг нь хэрэглэгч /нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэд/ Нийгмийн даатгалын үйлчилгээнээс гарч буй чанарын түвшин буюу тухайн үйлчилгээг хэрхэн үнэлж байгааг илтгэдэг бөгөөд үр дүн нь тоон хэмжүүрт тулгуурласан байдаг.

АЧ ХОЛБОГДОЛ: Хэрэглэгчийн тухайн Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээнээс хүлээж буй хүлээлт хүссэн үйлчилгээг нь үр дүнтэй болгох.

СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ: Санал асуулгын арга ашиглан SPSS программ дээр шинжилнэ.

СУДАЛГААНЫ БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- Судалгааны үр дүн нь ач холбогдолтой, үйл ажиллагаанд шууд авч ашиглах боломжтой байх.
- Хөндлөнгийн хараат бус байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн аргачлал арга зүйг судалгааны бүхий л үе шатанд дагаж мөрдөх

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ: Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэсийн үйлчилгээний А заал 101 тоотоос иргэдээс нээлттэй байдлаар санал асуулга авсан.




СУДАЛГААНЫ АСУУЛГУУД

Хүснэгт:1

Асуулт:1			
		Иргэдийн тоо	Хувь
Таны хүйс	Эрэгтэй	51	32.2%
	Эмэгтэй	107	67.8%
Нийт		158	100.0%

График:1




Дүгнэлт: Нийгмийн даатгалын хэлтсээр үйлчлүүлэхээр ирсэн иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авахад 158 даатгуулагч хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан иргэдийг хүйсээр авч үзвэл 67.8% эмэгтэй, 32.2% нь эрэгтэй гэсэн тоон үзүүлэлт гарч байна.



Хүснэгт:2

Асуулт:2			
		Иргэдийн тоо	Хувь
Таны нас	16-21	3	1.9%
	22-30	22	13.9%
	31-40	54	34.2%
	41-50	53	33.5%
	50-ээс дээш	26	16.5%
Нийт		158	100.0%

График:2




Дүгнэлт: Насны хувьд авч үзвэл 16-21 насны 3 даатгуулагч, 22-30 насны 22 даатгуулагч, 31-40 насны 54 даатгуулагч, 41-50 насны 53 даатгуулагч, 50-иас дээш насны 26 даатгуулагч судалгаанд хамрагдсан байна. Нийгмийн даатгалын байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдийн ихэнх хувь нь 31-40 насныхан буюу 34.2% байна.



Хүснэгт:3

Асуулт:3			
		Иргэдийн тоо	Хувь
Та хэдэн тоотын байцаагчаас үйлчилгээ авсан бэ?	1	25	15.8%
	2	0	0%
	3	26	16.5%
	4	0	0%
	5	0	0%
	6	20	12.7%
	7	0	0%
	8	0	0%
	9	0	0%
	10	37	23.4%
	Угтах үйлчилгээ	50	31.6%
Нийт		250	100.0%

График:3



Дүгнэлт: Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээний хэсэгт нийт 4 байцаагч, угтах үйлчилгээний ажилчид зөвлөгөө мэдээлэл үйлчилгээг иргэд, даатгуулагчдад хүргэн ажилласан байна.



Хүснэгт:4

Асуулт:4			
		Иргэдийн тоо	Хувь
Та яг одоо ямар үйлчилгээ авахаар ирсэн бэ?	Тэтгэвэртэй холбоотой мэдээлэл, үйлчилгээ	33	21.0%
	Тэтгэмжтэй холбоотой мэдээлэл, үйлчилгээ	42	26.0%
	Эрүүл мэндийн даатгалтай холбоотой мэдээлэл, үйлчилгээ	36	23.0%
	Сайн дурын даатгалтай холбоотой мэдээлэл, үйлчилгээ	30	19.0%
	Нийгмийн даатгалын тайлантай холбоотой үйлчилгээ	3	2.0%
	Лавлагаа	12	8.0%
	Бусад	2	1.0%
	Нийт		250

График:4



Дүгнэлт: Судалгаанд оролцсон даатгуулагчдын ихэнх буюу 42 даатгуулагч (26.0%) нь тэтгэмжийн даатгалтай холбоотой үйлчилгээ, мэдээлэл, зөвлөгөө авахаар ирдэг бол 33 даатгуулагч буюу 21.0% нь тэтгэвэр, 36 даатгуулагч буюу 23.0% нь эрүүл мэндийн даатгал, 30 даатгуулагч буюу 19.0% нь сайн дурын даатгалын мэдээлэл, үйлчилгээ авахаар ирсэн байна. Түүнчлэн үлдсэн даатгуулагчдын хувьд нийгмийн даатгалын тайлан, шимтгэл төлөлтийн лавлагааны талаар мэдээлэл зөвлөгөө авахаар ирсэн байна.



Хүснэгт:5

Асуулт:5			
		Иргэдийн тоо	Хувь
Та үйлчилгээ авахын тулд хэдэн минут хүлээсэн бэ?	Шууд үйлчлүүлсэн	146	58.4%
	5-15 минут	84	33.6%
	15-30 минут	17	6.8%
	30 минутаас 1 цаг	2	0.8%
	1-2 цаг	1	0.4%
Нийт		250	100.0%

График:5



Дүгнэлт: Хүлээлгийн хугацааны хувьд иргэдийн 93.7% буюу 148 иргэн нийгмийн даатгалын үйлчилгээ авахын тулд шууд үйлчлүүлсэн бол 4.4% буюу 7 даатгуулагч 5-15 минут хүлээж үйлчлүүлсэн байна. Үлдсэн 1.9% буюу 3 иргэн 15-30 минут буюу түүнээс дээш хугацаагаар хүлээсэн гэсэн байна. Энэ нь манай байгууллагын хувьд иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд хүлээлгийн хугацаа дээр ямар нэгэн хүндрэл, чирэгдэлгүй хурдан шуурхай үйлчилж байгаа нь харагдаж байна.



Хүснэгт:6

Асуулт:6		
	Иргэдийн тоо	Хувь
Тухайн байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу?	Бүрэн өгч чадсан	157 99.4%
	Хангалтгүй	1 0.6%
	Бүрэн өгч чадаагүй	0 0%
	Муу	0 0%
Нийт	158	100.0%

График:6




Дүгнэлт: Тухайн байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу? асуулгын хувьд нийт судалгаанд оролцогчдын 99.4% буюу 157 даатгуулагч “Бүрэн өгч чадсан” гэсэн хариулт өгсөн бол 0.6% буюу 1 даатгуулагч “Хангалтгүй” байна гэсэн үнэлгээ өгсөн. Ихэнх даатгуулагч бүрэн гүйцэт мэдээлэл авч чадсан нь дээрх үзүүлэлтээс харагдаж байна.



Хүснэгт:7

Асуулт:7			Иргэдийн тоо	Хувь
Та байцаагчийн мэргэжлийн ур чадварыг хэрхэн үнэлэх вэ?	Маш сайн	39	24.7%	
	Сайн	118	74.7%	
	Дунд	1	0.6%	
	Муу	0	0%	
Нийт		158	100.0%	

График:7



Дүгнэлт: Та байцаагчийн мэргэжлийн ур чадварыг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуулгын хувьд 24.7% буюу 39 даатгуулагч байцаагчийн мэргэжлийн ур чадварыг “Маш сайн” гэж үнэлсэн бол 74.7% буюу 118 даатгуулагч “Сайн” гэж үнэлсэн байна. Бусад даатгуулагчдын хувьд 0.6% буюу 1 даатгуулагч “Дунд” гэж үнэлсэн байна.



Хүснэгт:8

Асуулт:8		Иргэдийн тоо	Хувь
Нийгмийн даатгалын хэлтсийн ажилчдын ёс зүй, зан харьцаа, хандлагыг хэрхэн үнэлж байна вэ?	Маш өндөр ханамжтай	36	22.8%
	Сэтгэл ханамжтай	122	77.2%
	Сэтгэл ханамжгүй	0	0%
Нийт		158	100.0%

График:8




Дүгнэлт: Үйлчилгээ авсан байцаагчийн ёс зүй, харьцаа, хандлагын хувьд хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуултын хувьд 77.2% буюу нийт 122 даатгуулагч “Сэтгэл ханамжтай” бол 22.8% буюу 36 даатгуулагч нь “Маш өндөр ханамжтай” гэсэн хариулт өгсөн байна. Нийгмийн даатгалын хэлтсийн ажилчдын ёс зүй, зан харьцаа, хандлага сайн байгааг дээрх үзүүлэлт харуулж байна.



Хүснэгт:9

Асуулт:9			
		Иргэдийн тоо	Хувь
Байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай байна вэ?	Маш сайн	28	17.7%
	Сайн	130	82.3%
	Дунд	0	0%
Нийт		158	100%

График:9




Дүгнэлт: Байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай байна вэ? гэсэн асуулгын хувьд 17.7% буюу 28 даатгуулагч сэтгэл ханамж “Маш сайн”, 82.3% буюу 130 даатгуулагч сэтгэл ханамж “Сайн” гэсэн хариулт өгсөн байна. Үүнээс дүгнэхэд даатгуулагчид байцаагчийн үйлчилгээнд сэтгэл ханамжтай байгаа нь харагдаж байна.



Хүснэгт:10

Асуулт:10			
		Иргэдийн тоо	Хувь
Нийгмийн даатгалын үйлчилгээг олон дамжлагагүй 1 ажилтнаас авдаг болсныг та хэрхэн үнэлэх вэ?	Маш сайн	31	19.6%
	Сайн	126	79.7%
	Дунд	1	0.6%
	Дунд	1	0.4%
Нийт		250	100.0%

График:10



Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээг олон дамжлагагүй 1 ажилтнаас авдаг болсныг та хэрхэн үнэлэх вэ? асуулгыг авч үзвэл даатгуулагчдын 19.6% буюу 31 даатгуулагч “Маш сайн”, 79.8% буюу 126 даатгуулагч “Сайн”, 0.6% буюу 1 даатгуулагч “Дунд”, муу гэж үнэлгээ өгсөн даатгуулагч байхгүй байна.



Хүснэгт:11

Асуулт:11			
		Иргэдийн тоо	Хувь
Та нийгмийн даатгалын нэг үйлчилгээ авахын тулд хэдэн удаа ирэх шаардлагатай болдог вэ?	1 удаа	120	75.9%
	2 удаа	38	24.1%
	3-4 удаа	0	0%
	5-с дээш удаа	0	0%
Нийт		158	100.0%

График:11



Дүгнэлт: Та нийгмийн даатгалын нэг үйлчилгээ авахын тулд хэдэн удаа ирэх шаардлагатай болдог вэ? гэсэн асуулгын хүрээнд даатгуулагчдын ихэнх хувь 75.9% буюу 120 нь нийгмийн даатгалын нэг үйлчилгээ авахын тулд “1 удаа” ирэх шаардлага гарсан, 24.1% буюу 38 даатгуулагч нэг удаа үйлчилгээ авахын тулд “2 удаа” ирсэн байна. Нийгмийн даатгалын нэг үйлчилгээ авахын олон дахин ирэх шаардлагагүйгээр шууд үйлчилгээгээ авч байгаа нь харагдаж байна.



Хүснэгт: 12

Асуулт: 12			
		Иргэдийн тоо	Хувь
Нийгмийн даатгалын үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг үнэлнэ үү?	Маш сайн	19	12.0%
	Сайн	133	84.2%
	Дунд	6	3.8%
Нийт		158	100.0%

График:12



Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг үнэлнэ үү? Гэсэн асуулгын хувьд үйлчилгээний ил тод нээлттэй байдлын хувьд иргэдийн дийлэнхи хувь буюу 84.2% буюу 133 даатгуулагч “Сайн”, 12.0% буюу 19 даатгуулагч нийгмийн даатгалын үйлчилгээний ил тод нээлттэй байдалд “Маш сайн”, 3.8% буюу 6 даатгуулагч үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг үнэлэхдээ “Дунд” гэж хариулсан байна.



Хүснэгт:13

Асуулт:13			
		Иргэдийн тоо	Хувь
Ажилтнуудын буруутай үйлдлээс болж таньд ямар нэгэн хүндрэл, чирэгдэл учирч байсан уу?	Тийм	4	2.5%
	Үгүй	154	97.5%
Нийт		250	100.0%

График:13



Дүгнэлт: Иргэд, даатгуулагчдад ямар нэгэн хүндрэл чирэгдэл учруулж, хүнд суртал гаргаж байсан эсэх асуултанд нийт даатгуулагчийн 97.5% буюу 154 даатгуулагч “үгүй” гэсэн хариулт өгсөн. Үүнээс 2.5% буюу 4 даатгуулагч дээрх асуултанд “тийм” гэсэн хариулт өгснөөр эдгээр иргэдэд ямар нэгэн хүндрэл, чирэгдэл учирсан байна.



Хүснэгт:14

Асуулт:14			
		Иргэдийн тоо	Хувь
Нийгмийн даатгалын хэлтсийн дотоод орчин нөхцөл, тав тухыг хэрхэн үнэлж байна вэ?	Маш сайн	17	10.8%
	Сайн	114	77.2%
	Боломжийн	25	15.8%
	Муу	2	1.3%
Нийт		158	100%

График:14



Дүгнэлт: Тав тух, орчин нөхцөлийн хувьд иргэд даатгуулагчдын эерэг сэтгэгдэлтэй буюу хэлтсийн зохион байгуулалт дотоод орчин нөхцөлийг 10.8% буюу 17 “Маш сайн” , 77.2% буюу 114 даатгуулагч “Сайн”, 15.8% буюу 25 даатгуулагч “Боломжийн” гэж үнэлсэн байна. Нийгмийн даатгалын хэлтсийн дотоод орчинг 1.3% буюу 2 даатгуулагч муу гэж үнэлсэн байна.



Асуулт 15. Танд нийгмийн даатгалын үйлчилгээг сайжруулах ямар нэгэн санал, хүсэлт байвал чөлөөтэй бичнэ үү?

1. Амжилт, амжилт.
2. Баярлалаа.
3. Лист удаж байна.
4. Лист удаж байна.
5. Баярлалаа.
6. Хурдан шуурхай үйлчилж мээдээллийг маш ойлгомжтой цэгцтэй өгч үйлчилсэнд баярлалаа.
7. Амжилт хүсье.
8. Баярлалаа.
9. Тэвдэж явахад уриалгахан тус үзүүлсэн 10 эгчдээ баярлалаа.
10. Амжилт хүсье.
11. Ард иргэдтэйгээ зөв боловсон харьцаатай хамт олонд нь ажлын өндөр амжилт хүсье. Баярлалаа.
12. Баярлалаа.
13. Сэтгэл ханамж маш сайн байлаа. Баярлалаа.
14. Үнэхээр сэтгэл ханамж өндөр авах мэдээлэлээ бүрэн гүйцэт илүү авч чадсан.
15. Баярлалаа.
16. Та бүхэнд ажлын өндөр амжилт хүсье.



**Эерэг
сэтгэгдэл-14**



Санал хүсэлт-0




**Сөрөг
сэтгэгдэл-2**



16. Байцаагчийн буруутай үйлдлээс болж ямар нэгэн хүндрэл, чирэгдэл учирч байсан уу? гэсэн асуултыг авч үзэхэд:


График:16



Дүгнэлт: Дээрх графикаас харахад даатгуулагчдад тодорхой хэмжээгээр ажилтны буруутай үйлдлээс болж хүндрэл, чирэгдэл учирдаг нь харагдаж байна.

17. Байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлагын үнэлэмжийн хувьд дараах үзүүлэлттэй байна:

График:17




Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлж байгаа байцаагчийн хувьд үйлчилгээ авч буй даатгуулагчид маш өндөр сэтгэл ханамжтай, сэтгэл ханамжтай байгааг харуулж байна.



18. Тухайн байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу? гэсэн асуултыг авч үзэхэд:


График:18



Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлж байгаа байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу? гэсэн асуултын хувьд 10 дугаартай байцаагчийн хувьд 36 даатгуулагч хүссэн мэдээллийг бүрэн өгч чадсан бол 1 даатгуулагчид хангалтгүй мэдээлэл өгсөн байна. Мөн 2 дугаартай байцаагчаас үйлчилгээ авч буй иргэдийн хувьд 26 даатгуулагчдад мэдээлэл бүрэн өгч чадсан байна.

19. Байцаагчийн мэргэжлийн ур чадварыг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуултыг авч үзэхэд:

График:19




Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлж байгаа байцаагчийн мэргэжлийн ур чадварыг үнэлэхдээ 10 дугаартай байцаагчийн хувьд 15 даатгуулагч маш сайн, 22 даатгуулагч сайн гэж үнэлсэн бол 3, 6 дугаартай байцаагчийн мэргэжлийн ур чадварыг үнэлэхдээ 7 даатгуулагч маш сайн, 19 болон 13 даатгуулагч сайн гэж үнэлсэн байна.



20. Та байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай вэ? гэсэн асуулт дараах үзүүлэлттэй байна.

График:20




Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэдийн байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай вэ? гэсэн асуулгын хувьд 10 дугаартай байцаагчаас үйлчилгээ авч байгаа 9 даатгуулагч маш сайн, 28 даатгуулагч сэтгэл ханамж сайн гэж хариулсан байна. 6 дугаартай байцаагчийн үйлчилгээнд 6 даатгуулагч сэтгэл ханамж маш сайн, 14 даатгуулагч сайн гэж үнэлсэн байна. Үүнээс үзэхэд нийгмийн даатгалын үйлчилгээг авч буй иргэдийн хувьд үйлчилгээнд сэтгэл ханамжтай байна.

Сэтгэл ханамжийн индексийн үнэлгээ:

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинг үнэлүүлэхдээ 1-10 гэсэн Лайкерьтын шкал (хэмжүүр) ашигласан болно. Уг индексийн агуулгын хувьд 9.00-10.00 байвал хэрэглэгч маш сэтгэл ханамжтай бөгөөд энэ нь бодит нөхцөл байдал дээр тийм ч олон тохиолддоггүй онолын түвшиний ойлголт юм. 8.00- 8.99 хооронд тохиолдолд сэтгэл ханамжтай ба байгууллагууд энэ түвшинд байхад харьцангуй санаа зовох зүйл бага байдаг. Харин 6.00-8.00 хооронд хэрэглэгчийн сэтгэл ханамж дээгүүр түвшинд байгаа бөгөөд цаашид нэмэгдүүлэх шаардлагатайг илэрхийлсэн мэдээлэл юм. Харин 5.99-өөс доош байгаа бол энэ




Та байцаагчийн мэргэжлийн ур чадварыг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал:



Дүгнэлт: Та байцаагчийн мэргэжлийн ур чадварыг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулан үзэхэд 6 дугаартай байцаагчийн хувьд индекс нь 8.38 уг үзүүлэлт нь байцаагчийн мэргэжлийн ур чадварыг сайн байна гэж үнэлсэн бол 10 дугаартай байцаагчийн хувьд 8.71 индекстэй гарсан байна.


Тухайн байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу? асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал:



Дүгнэлт: Тухайн байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу? Гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал 1, 3, 6 угтах үйлчилгээ байцаагчийн үзүүлэлт өндөр гарсан байна. Үүнээс үзэхэд 1, 3, 6 угтах үйлчилгээ дугаартай байцаагчийн хувьд иргэдэд хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан байна.




Үйлчилгээ авсан байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлагыг та хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал:



Дүгнэлт: Үйлчилгээ авсан байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлагыг та хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуултад байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал 3, 10 дугаартай байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлага 8.7 байгаа нь иргэдийн сэтгэл ханамж өндөр байгааг харуулж байгаа бол 6 дугаартай байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлага 8.38 үзүүлэлттэй байна.

Та байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай вэ? гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал:




Дүгнэлт: Та байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай вэ? гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал 10 дугаартай байцаагчийн хувьд 9.75 байгаа нь байцаагчийн үйлчилгээнд сэтгэл ханамж маш сайн байгааг харуулж байна. 6 дугаартай байцаагчийн үйлчилгээнд сэтгэл ханамж 8.6 байгаа нь байцаагчийн үйлчилгээнд сэтгэл ханамжтай байгааг илэрхийлж байна.



ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ БУЙ БАЙЦААГЧИЙН НЭРС

№	Үйлчилгээ үлүүлж буй дугаар	Байцаагчийн нэрс
1	1 дугаартай	Б.Анар
2	2 дугаартай	
3	3 дугаартай	Н.Батэрдэнэ
4	4 дугаартай	
5	5 дугаартай	
6	6 дугаартай	Д.Отгонтуяа
7	7 дугаартай	
8	8 дугаартай	
9	9 дугаартай	
10	10 дугаартай	Б.Раяа
	Угтах үйлчилгээ	Анхмаа, Мягмарчулуун

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэсийн 7 сарын үйлчилгээ, орчин нөхцлийг үнэлэх судалгааны 10-н асуултыг индекслэхэд **8.50** байна.



Судалгааны нэгтгэл хийсэн: Н.Оюун-Эрдэнэ/...../

